

## ХӨЛӨНБУЙР БҮСИЙН ХҮН АМЫН ХӨГЖЛИЙН ҮНЭЛГЭЭ

**Фен Хува**<sup>1</sup>, магистр, Хөлөнбуйрын дээд сургуулийн Хууль-Эдийн засгийн дээд сургуулийн дэд профессор.

**Сүн Чи Иой**, доктор, Хөлөнбуйрын дээд сургуулийн Хууль-Эдийн засгийн дээд сургуулийн дэд профессор.

### Хураангуй:

Судалгааны гол зорилго нь Өвөр Монголын өөртөө засах орон (ӨМӨЗО)-ы Хөлөнбуйр бүс, түүний харьяа засаг захиргааны нэгжүүдийн хүн амын хөгжлийн түвшнийг олон хэмжээсээр үнэлж, тэдгээр нь нийгэм, эдийн засгийн хөгжилдөө хэр ээлтэй байгаа талаар дүгнэлт өгөх явдал юм. Үнэлгээг хүн амын хөгжлийн гурван дэд хэмжээс (тоо, өсөлт; амьдралын чанар; бүтэц)-т багтах 20 үзүүлэлтээр “хүн амын хөгжлийн нэгдсэн индекс үүсгэх” аргаар, БНХАУ-ын 2020 оны үндэсний хүн амын тооллогын мэдээлэл ашиглан гүйцэтгэсэн. Судалгааны дүнгээс үзэхэд хүн амын хөгжлийн ерөнхий түвшин Хөлөнбуйр дотроо засаг захиргааны нэгжүүдээр ялгаатай (Хайлаар, Манжуур, Шинэ баруун Барга хошуунд “өндөр”, Эвэнх, Хуучин Барга хошуунд “дундаас дээгүүр”, Шинэ зүүн Барга хошуу, Эргүнэ, Арын хошуу, Морин даваа, Жалан-Айлд “дунд”, Жалайнуурт “бага”, Орчон, Ягши, Гэгээнголд “маш бага”) байв. Иймд Хөлөнбуйр бүсийн нийгэм, эдийн засгийн цаашдын хөгжлийг дэмжихэд шаардлагатай хүн амын хөгжлийг бүрдүүлэхийн тулд дээрх орон нутгууд одоогоор хүн амын өөр өөр асуудалд анхаарал хандуулж, ялгаатай арга хэмжээнүүд хэрэгжүүлэх шаардлагатай.

**Түлхүүр үг:** Хөлөнбуйр бүс; хүн амын хөгжил; хүн амын хөгжлийн хэмжүүр; олон хэмжээст индекс

### ASSESSMENT OF POPULATION DEVELOPMENT IN THE HULUNBUIR REGION

#### Abstract

The study assesses the level of population developments in the Hulunbuir region of the Inner Mongolia Autonomous Region (IMAR) and its administrative units across multiple dimensions, with the aim of evaluating their implications for social and economic development. A composite index of population development was constructed using 20 indicators grouped into three sub-dimensions: population size and growth, quality of life, and structure. Data were drawn from the 2020 National Population Census of the People's Republic of China. The findings reveal significant variation in population development across Hulunbuir's administrative units: 'high' levels in Hailar, Manzhouli, and New Barga West County; 'above average' in Ewenki and Prairie Chenbarhu Banner; 'average' in New Barga East County, Ergun, Arong, Morin Dawa, and Zhalantun; 'low' in Jalainur; and 'very low' in Oroqin, Yakeshi and Genhe. Therefore, to promote the future social and economic development of the Hulunbuir region, it is necessary for the aforementioned localities to currently focus on different population challenges and implement diverse measures.

**Keywords:** Hulunbuir region; population development; population development measure; multidimensional index

## 1. ОРШИЛ

БНХАУ-ын долоо дахь удаагийн хүн амын тооллогын бүртгэлд Ши Жиньпин оролцох үеэрээ хэлсэн үгэндээ: “Хүн амын асуудал бол манай улсын өмнө тулгамдаж буй ерөнхий, урт хугацааны, стратегийн асуудал байсаар ирсэн. Сүүлийн жилүүдэд манай улсын хүн амын хөгжил нь хүн ам зүйн бүтэц, өөрчлөлтийн хувьд асар олон бэрхшээл, сорилттой тулгарсаар ирсэн” гэж тэмдэглэсэн байдаг.

<sup>1</sup> Холбоо барих зохиогч. Хаяг: [fh\\_zha@126.com](mailto:fh_zha@126.com)

Аливаа улс, бүс, орон нутгийн хөгжилд хүн ам зүйн нөхцөл байдал чухал үүрэгтэй. Хүн амын тоо хэмжээ, өсөлт, насны бүтэц, эдийн засгийн хувьд тэжээлгэгч болон тэтгэгч хүн амын харьцаа, хүн амын урт наслалт, мэдлэг боловсролын түвшин, ажил, орлогын байдал зэрэг олон үзүүлэлт улс, бүс, орон нутгийн хөгжлийн байдал, бодлого боловсруулалт, шийдвэр гаргалтад шууд нөлөөлдөг. Хүн ам зүйн болон хүн амын амьдралын чанарын нөхцөл байдал нь нийгэм, эдийн засгийн хөгжлөө дэмжихүйц байдалд байгаа нутаг, орнуудад хөгжил хурдацтай явагдах боломжтой ч энэхүү таатай нөхцөлийг судлан илрүүлж, шийдвэр гаргагчдад мэдээллийг хүргээгүй тохиолдолд хөгжих боломжоо ашиглахгүй өнгөрөөх ч боломжтой. Эсрэгээр, хүн ам зүйн болон хүн амын амьдралын чанарын нөхцөл байдал нь нийгэм, эдийн засгийн хөгжилдөө саад тотгор болохоор байгаа нутаг орнууд мөн л зохих судалгаа хийж, арга хэмжээ хэрэгжүүлэхгүй бол хөгжил удаашрах, эсвэл бүр дордох ч эрсдэлтэй. Иймд, тооллого, судалгаануудад нарийвчилсан дүн шинжилгээ хийх замаар хүн амын хөгжлийн стратеги, бодлогын тогтолцоог боловсронгуй болгох нь нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих чухал суурь болдог.

Хүн амын хөгжил нийгэм, эдийн засагтаа үзүүлж буй нөлөөллийг хэмжихэд олон хэмжээст индексийг ашиглах практик сүүлийн жилүүдэд олон улсад нэмэгдэж байгаа ч харьцангуй цөөн хүн амтай улс, бүс, нутаг орны хувьд энэ төрлийн судалгаа ховор хийгдсэн байна. Нөгөө талаас, дэлхийн улс орнуудад 2020 онд асар их нөөц, хүчин чармайлт зарцуулан ээлжит хүн амын тооллогууд хийгдсэн бөгөөд тэдгээр нь хүн амын хөгжлийг бүс, орон нутгуудын түвшинд нарийвчлан үнэлэх өргөн боломжийг бий болгосон. Гэвч харьцангуй цөөн хүн амтай бүс, орон нутгуудын хувьд хүн амын нөхцөл байдал буюу хүн амын хөгжлийн байдал ямар боломж, сорилтууд үүсгэж байгааг судалсан ажлууд тийм ч хангалттай хийгдээгүй байна. БНХАУ-ын хувьд ч 2020 онд Хүн амын долоо дахь удаагийн тооллогоо зохион байгуулсан ба түүний өгөгдлийг бүс, орон нутгийн түвшинд нарийвчлан шинжлэх, төлөвлөлт, шийдвэр гаргалтуудад ашиглах шаардлага байгаа юм.

Иймд, энэхүү ажилд 2020 оны хүн амын тооллогоор 2.2 сая хүн амтай хэмээн тоологдсон БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр бүсийн хүн амын хөгжлийн байдлыг олон хэмжээст индекс ашиглан үнэлэх зорилго дэвшүүлсэн. Шинжилгээг Хөлөнбуйр бүсийн засаг захиргааны 14 нэгжийн хувьд мөн задлан хийж, бүсийн доторх хүн амын хөгжлийн ялгаатай байдлыг үнэлсэн.

Хөлөнбуйр нь ӨМӨЗО-ны нутаг дэвсгэрт байрлах бөгөөд Хөлөн, Буйр гэсэн хоёр нуурын нэрээр нэрлэгдсэн, хот статустай бүс юм. Газар нутаг нь 263,000 км.кв талбайг хамардаг буюу ойролцоогоор Их Британийн газар нутагтай дүйцнэ. Хөлөнбуйр Оросын Холбооны Улс, Монгол Улстай нэг хил дээр уулздаг БНХАУ-ын цорын ганц хот бөгөөд БНХАУ-ын хамгийн том, хамгийн бүрэн бүтэн экосистемтэй бүс гэдгээрээ онцлог. Эрт дээр үеэс Сяньби, Кидан, Жүрчэн ард түмэн оршин суудаг байсан Хөлөнбуйр бол умард зүгийн ан агнуур, нүүдлийн уламжлалын өлгий нутаг гэгддэг ба өнөөгийн байдлаар орчин үеийн хуурай боомтыг бэлчээрийн аж ахуйтай хослуулсан нутаг болоод байна. Ашигт малтмалын нөөц баялаг, хил дамнасан худалдааны гол замуудтай Хөлөнбуйр нь Хятадын “Бүс ба зам” санаачилгын хувьд Зүүн Хойд Азийн стратегийн төв газар юм.

Энэхүү судалгааны ажил нь Хөлөнбуйр бүсэд “нийгэм, эдийн засгийн хөгжилд эергээр нөлөөлөхүйц” хүн амын хөгжлийг бий болгох, хадгалахад анхаарах шаардлагатай бодлогын чиглэлүүдийг тодорхойлох, мөн Хөлөнбуйр бүсийн хүн амын хөгжлийн асуудлаарх судалгаа, шинжилгээний дутагдалтай байдлыг нөхөх ач холбогдолтой юм.

## 2. СУДЛАГДСАН БАЙДАЛ

“Хятадын нэвтэрхий толь (Нийгмийн толь)”-д хүн амын хөгжил гэдгийг нийгмийн амьдралын гол бүрэлдэхүүн бөгөөд бүтээмжийн өсөлт, нийгмийн үйлдвэрлэлийн арга барил, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал өөрчлөгдөхийн хэрээр хүн амын тоо, чанар, бүтэц өөрчлөгдөж, доод түвшнээс дээд түвшинд шилжин, дэвшилд хүрэх үйл явц юм гэж тодорхойлсон байдаг (Жуу

Сан Жиюун 2015). Энэхүү тодорхойлолт нь өргөн хүрээтэй, ойлгоход хялбар бөгөөд хүн амын тоо ба өөрчлөлт, хүн амын амьдралын чанар, хүн амын бүтэц нь хүн амын хөгжлийг хэмжих үндсэн гурван элемент болохыг онцолсон.

Хүн амын хөгжлийг хэмжихтэй холбоотой сүүлийн үед хийгдэж байгаа судалгааны ажлуудад хүн ам зүйн тогтолцоо буюу хүн ам зүйн өөрчлөлтийн талаарх үнэлгээ, хүн ам ба эдийн засгийн нөөцийг холбосон үнэлгээ, дээрх бүгдийг цогцоор нь багтаасан үнэлгээ буюу хүн амын системийн цогц үнэлгээ гэсэн гурван багц үзүүлэлтийг түгээмэл хэрэглэсэн байна. Судлаач Жуу Сан Жиюун (2015) “Шандун мужийн хүн амын хөгжлийн цогц үнэлгээ” ажилдаа хүн амын хөгжлийг хэмжихдээ хүн амын төрөлтийн ерөнхий түвшин, хүн амын амьдралын чанарын индекс, төрөлтийн нийлбэр коэффициент, төрөх үеийн хүйсийн харьцаа, дундаж наслалт, хүн амын дундаж боловсролын түвшин буюу дундаж суралцсан жил, хөдөлмөрийн насны хүн амын хувь, хүн амын шилжилт хөдөлгөөн зэрэг үзүүлэлтийг хамруулан судалжээ. (Жуу Сан Жиюун, 2015). Зарим судлаач дээрх үзүүлэлтүүд дээр нэмэлтээр, хүн амын бага болон дунд сургуульд элсэлтийн түвшин, нийгмийн халамж хүртэгчдийн тооны харьцаа зэргийг авч үзсэн байдаг.

Гуу Шин өөрийн ажилдаа хүн амын хөгжлийг үнэлэхдээ хүн амын тоо хэмжээ, чанар, бүтэц, тархалт зэрэг дөрвөн багц үзүүлэлтийг ашигласан байна (Гуу Шин, 2014). Ван Жун (2012)-ы судалгаанд хүн амын хөгжлийн хэмжүүрт хүн амын механик өсөлт, хот хөдөөгийн хүн амын харьцаа, 10'000 хүн амд ногдох оюутны тоо зэрэг үзүүлэлтүүдийг нэмэн судалсан байна (Ван Жун, 2013). Хун Чи (2012)-ийн боловсруулсан хүн амын хөгжлийн үзүүлэлт өмнөх судалгаануудынхтай төстэй боловч хүн амын бичиг үсэгт тайлагдалтын түвшин, 10'000 хүнд ногдох шинжлэх ухаан технологийн ажилтны тоо, хүн амын нягтрал, дээд боловсрол эзэмшилтийн хувь зэргийг авч үзсэнээрээ онцлог байв (Хун Чи, 2012).

Сүүлийн жилүүдэд Хятад Улсын хувьд хийгдсэн судалгааны ажлуудаас харвал, хүн амын хөгжлийг Лияан Хун (2021) хүн амын тоо, тархалт, насны бүтэц, боловсролын түвшин гэсэн дөрвөн багц үзүүлэлтээр, Ян Шиюу Ан (2022) хүн амын тоо, бүтэц, чанар ба тархалт гэсэн багц үзүүлэлтээр тус тус үнэлсэн байна (Лияан Хун, 2021 Ян Шиюу Ан, 2022). Дээрх бүгдээс харвал судалгааны ажлуудад авч үзсэн хүн амын хөгжлийн хэмжүүр үзүүлэлтүүд ерөнхийдөө төстэй, нийтлэг бөгөөд индекс хэлбэрээр ашиглах боломжтой байна.

### 3. АРГА ЗҮЙ

#### 3.1 Хүн амын хөгжлийн индекс, түүний бүрэлдэхүүн үзүүлэлтүүд

Энэхүү ажилд ӨМӨЗО-ны Хөлөнбуйр бүсийн хүн амын хөгжлийн түвшнийг олон хэмжээст индексээр үнэлсэн. Индекс нь 1) *хүн амын тоо, өсөлт*, 2) *хүн амын амьдралын чанар*, 3) *хүн амын бүтэц* гэсэн гурван багц дэд хэмжүүрээс бүрдсэн ба багц тус бүр дотроо 5-8 үзүүлэлтийг агуулна. Тухайлбал, “хүн амын тоо, өсөлт”-ийн хэмжээс 5 үзүүлэлтээс, “хүн амын амьдралын чанар”-ын хэмжээс 7 үзүүлэлтээс, “хүн амын бүтэц”-ийн хэмжээс 8 үзүүлэлтээс бүрдсэн ба индекс нийтдээ 20 үзүүлэлтэд тулгуурлан бүтээгдсэн.

Хүн амын хөгжлийн индексэд оруулах бүрэлдэхүүн үзүүлэлтүүдийг сонгохдоо дараах нөхцөл, шалгууруудыг харгалзсан. Үүнд:

- Өмнө хийгдсэн судалгааны ажлуудад ашиглагдсан хэмжүүрүүдийг багтаах,
- Судалж буй орон нутгийн онцлогийг харгалзан үзэх,
- БНХАУ-ын 2020 оны хүн амын тооллогоос гаргах боломжтой үзүүлэлтүүдийг ашиглах зэрэг багтсан.

Ижил төстэй сэдэв бүхий судалгаанд бусад судлаачдын ашигласан үзүүлэлтүүдээс хот хөдөөгийн хүн амын орлогын харьцаа, бага, дунд сургуулийн хамран сургалтын түвшин, 10'000 хүнд ногдох шинжлэх ухаан, технологийн боловсон хүчний тоо зэрэг үзүүлэлтүүд тооллогоос гарах боломжгүй байсан тул ашиглаагүй болно.

Хүн амын хөгжлийн олон хэмжээст индексийн бүрэлдэхүүн үзүүлэлтүүдийн тодорхойлолт, тайлбарыг Хүснэгт 1-д харуулав.

**Хүснэгт 1. Хүн амын хөгжлийн олон хэмжээст индексийн дэд хэмжээс, бүрэлдэхүүн үзүүлэлтүүдийн тайлбар**

Дэд хэмжээс	Бүрэлдэхүүн үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Хөгжилд үзүүлэх нөлөө	Энтропийн жин*
<b>Хүн амын тоо, өсөлт (<math>S_1</math>)</b>	Хүн амын тоо	хүн	+	44.44%
	Төрөлтийн ерөнхий коэффициент (тухайн жилийн 1000 хүн амд ногдох төрөлтийн тоо)	‰	+	15.90%
	Нас баралтын ерөнхий коэффициент (тухайн жилийн 1000 хүн амд ногдох нас баралтын тоо)	‰	-	12.21%
	Хүн амын ердийн цэвэр өсөлтийн коэффициент (тухайн жилийн 1000 хүн амд ногдох төрөлт, нас баралтын зөрүү)	‰	+	11.84%
	Төрөлтийн нийлбэр коэффициент (1000 эмэгтэйн амьдралынхаа туршид төрүүлэх хүүхдийн тоо)	хүн	+	15.61%
<b>Хүн амын амьдралын чанар (<math>S_2</math>)</b>	Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоо)	‰	-	11.45%
	Дундаж наслалт (төрөх үеийн)	жил	+	22.45%
	Хүн амын сургуульд суралцсан дундаж хугацаа	жил	+	12.30%
	Насанд хүрэгчдийн бичиг үсэг үл мэдэлтийн түвшин (15+ насны нийт хүн амд бичиг үсэгт тайлагдаагүй хүн амын эзлэх хувь)	%	-	13.66%
	Дээд боловсролтой хүн амын хувь (25+ насны нийт хүн амд дээд боловсролтой хүн амын эзлэх хувь)	%	+	14.86%
	Хүүхдийн ачаалал (16-59 буюу хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох 0-15 насны хүн амын тоо)	хүн	-	11.93%
	Ахмадуудын ачаалал (16-59 насны 100 хүнд ногдох 60, түүнээс дээш настай хүн амын тоо)	хүн	-	13.36%
<b>Хүн амын бүтэц (<math>S_3</math>)</b>	Хүн амын хүйсийн харьцаа (100 эмэгтэй хүн амд ногдох эрэгтэй хүн амын тоо)	-	-	6.00%
	Төрөх үеийн хүйсийн харьцаа (шинэ төрсөн 100 эмэгтэй хүүхдэд ногдох эрэгтэй хүүхдийн тоо)	-	-	5.32%
	Нийт хүн амд ахмад (60, түүнээс дээш настай) хүн амын эзлэх хувь	%	-	12.71%
	Нийт хүн амд хөдөлмөрийн нас (16-59)-ны хүн амын эзлэх хувь	%	+	18.55%
	Хүн амын медиан нас (хүн амын тоог насны бүтцийн хувьд таллан хувааж буй нас)	жил	-	12.35%
	Шилжин ирэлтийн түвшин (1000 хүн амд ногдох тухайн жилд шилжин ирсэн хүн амын тоо)	‰	+	22.06%
	Хотын хүн амын хувь (нийт хүн амд эзлэх хотод амьдардаг хүн амын хувь)	%	+	9.76%
	Хөдөлмөрийн орлогоор амьжиргаагаа голлон залгуулдаг хүн амын хувь (Нийт хүн амд цалин, хөлс, хувиараа хөдөлмөр эрхлэлтийн орлогоор амьжиргаа залгуулдаг хүн амын эзлэх хувь)	%	+	13.25%

\*Мэдээлэл нь найдвартай бөгөөд бодлого төлөвлөлтөд их хэрэглэгддэг үзүүлэлтүүдэд илүү өндөр жин хуваарилдаг арга.

Эх сурвалж: БНХАУ-ын үндэсний хүн амын долоо дугаар тооллогын мэдээлэлд үндэслэсэн судлаачийн тооцоолол.

Үнэлгээнд 2020 онд явагдсан “БНХАУ-ын үндэсний хүн амын долоо дугаар тооллого”-ын мэдээллийг гол өгөгдөл болгосон.

### 3.2 Хүн амын хөгжлийн индексийн тооцоо

Сонгосон үзүүлэлтүүдэд тулгуурлан Хөлөнбуйр болон түүний засаг захиргааны нэгжүүдийн хувьд хүн амын хөгжлийн ерөнхий индексийг тооцохдоо Яин Сиү Яин (2017)-ий ашигласан аргаар, дараах шат дарааллаар гүйцэтгэсэн. Үүнд:

1. Гурван дэд хэмжээсийг бүрдүүлж буй өөр хэмжүүрүүдтэй 20 үзүүлэлтийг нэг хэмжүүрт шилжүүлэн стандартчилах.

Хэрэв үзүүлэлтийн хөгжилд үзүүлэх нөлөө сөрөг бол:

$$P_i = [X_i - \text{Min}(X_i)] / [\text{Max}(X_i) - \text{Min}(X_i)] \quad [1]$$

Хэрэв үзүүлэлтийн хөгжилд үзүүлэх нөлөө эерэг бол:

$$P_i = [\text{Max}(X_i) - X_i] / [\text{Max}(X_i) - \text{Min}(X_i)] \quad [2]$$

2. Үзүүлэлт бүрийн дэд хэмжээс дотроо эзлэх жинг энтропийн аргаар тогтоох. Үр дүнг Хүснэгт 1-д харуулав.
3. Хүн амын хөгжлийн гурван дэд хэмжээс тус бүрийн оноог тооцох.

$$S_i = \sum_{j=1}^m W_{ij} \cdot X_{ij} \quad [3]$$

Энд,  $i$ : дэд хэмжээснүүдийн дугаар ( $i=1, 2, 3$ );  $j$ : дэд хэмжээс доторх үзүүлэлтүүдийн дугаар;  $m$ : дэд хэмжээс доторх үзүүлэлтийн тоо (жишээлбэл, хүн амын тоо, өсөлтийн хувьд  $m=5$  байна);  $W_{ij}$ :  $i$ : дүгээр дэд хэмжээс доторх  $j$  дүгээр үзүүлэлтийн жингийн коэффициент;  $X_{ij}$ : сонирхож буй засаг захиргааны нэгжийн хувьд  $i$  дугаар дэд хэмжээс доторх  $j$  дүгээр үзүүлэлтийн стандартчилагдсан утга.

4. Хүн амын хөгжлийн ерөнхий индексийг тооцох.

Дэд хэмжээс тус бүр нь практикт эн тэнцүү ач холбогдолтой тул хүн амын хөгжлийн нэгдсэн индекс ( $S$ )-ийн утгыг гурван дэд хэмжээс (хүн амын тоо хэмжээ, өсөлт; хүн амын амьдралын чанар; хүн амын бүтэц)-ийн арифметик дунджаар тооцсон.

$$S = (S_1 + S_2 + S_3) / 3 \quad [4]$$

Дээрх индексээс гадна, хүн амын хөгжлийн гурван дэд хэмжээсний онооны зөрүү нь хүн амын хөгжлийн түвшнийг хэмжих өөр нэг жишиг үзүүлэлт юм. Үүнийг “хөгжлийн координацын индекс” буюу Developmental Coordination Index ( $D$ )-ээр хэмжсэн. Энэ үзүүлэлт нь  $S_1$ ;  $S_2$ ;  $S_3$  гэсэн дэд хэмжээсүүд нэг орон нутгийн хувьд хоорондоо хэр ойролцоо буюу жигд, тэнцвэртэй байгаа түвшнийг хэмжинэ.

$$D = 1 - \frac{S_d}{S} \quad [5]$$

Энд,  $D$  нь координацын түвшин;  $S_d$  нь  $S_1$ ;  $S_2$ ;  $S_3$  утгуудын стандарт хэлбэлзэл;  $S$  нь  $S_1$ ;  $S_2$ ;  $S_3$  утгуудын арифметик дундаж утга.

$D$ -ийн утга өндөр (1-д ойр) байх тусам тухайн бүс нутгийн хүн амын хөгжлийн бүрэлдэхүүнүүд болох хүн амын өсөлт, чанар, бүтэц ийн нөхцөл байдлууд хөгжилд үзүүлэх нөлөө нь жигд, ойролцоо болохыг харуулна. Харин  $D$ -ийн утга бага (0-д ойр) байх тусам тухайн бүс нутаг дахь хүн амын хөгжлийн бүрэлдэхүүнүүд тэнцвэргүй нөлөөтэй, ямар нэгэн дутагдалтай тал байгааг илтгэнэ.

## 4. ҮР ДҮН

### 4.1 Хөлөнбуйр бүсийн хүн ам зүйн нөхцөл байдал

ӨМӨЗО-ны Хөлөнбуйр бүс нь дотроо 14 засаг захиргааны нэгжид хуваагддаг. Хөлөнбуйр болон түүний засаг, захиргааны нэгжүүдийн хувьд “Хүн амын тоо, өсөлт” багцад хамаарах таван хэмжүүр үзүүлэлтийн нөхцөл байдлыг Хүснэгт 2-т, “Хүн амын амьдралын чанар” багцад хамаарах үзүүлэлтүүдийг Хүснэгт 3-т, “Хүн ам зүйн бүтэц”-д хамаарах үзүүлэлтүүдийг Хүснэгт 4-т тус тус харуулав.

Хүснэгт 2-оос харахад бүсийн хүн амын тоо орон нутгаараа нэлээд ялгаатай байна. Хөлөнбуйр бүсийн нийт хүн амын тоо 2020 оны тооллогоор 2,242,875 гэж тоологдсон бөгөөд 14 харьяа нэгжээс Хайлаар дүүрэг, Жалан-Айл хотууд хамгийн олон (319-365 мянга), харин Шинэ зүүн ба баруун Барга хошуунууд хамгийн цөөн (37-38.4 мянга) хүн амтай байна.

Төрөлтийн түвшин ихэнх орон нутагт бага байгаа ч Шинэ баруун Барга хошуу, Арын хошуу зэрэг зарим нэг орон нутаг бусдаасаа арай өндөр байна. Нас баралтын түвшнийг харвал Шинэ баруун Барга, Манжуур хотоос бусад орон нутагт төрөлтөөсөө өндөр байгаа тул Хөлөнбуйрын 14 орон нутгаас 12-т нь хүн амын байгалийн цэвэр өсөлт хасах утгатай, хүн амын тоо буурч байгааг харж болохоор байна. Ялангуяа Гэгээнгол хотод хүн амын тоо жилдээ 1000 хүн ам тутамд 12-13 хүнээр цөөрч байгаа нь орон нутгийн шийдвэр гаргагчдад анхаарал хандуулахыг шаардсан дохио болж байна.

#### Хүснэгт 2. Хөлөнбуйр бүс, түүний засаг захиргааны нэгжүүдийн хүн амын тоо, өсөлтийн үзүүлэлтүүд, 2020

Засаг, захиргааны нэгж	Хүн амын тоо, өсөлтийн үзүүлэлтүүд				
	Хүн амын тоо (хүн)	Төрөлтийн ерөнхий коэффициент (%)	Нас баралтын ерөнхий коэффициент (%)	Ердийн цэвэр өсөлтийн коэффициент (%)	Төрөлтийн нийлбэр коэффициент (1000 хүн амд ногдох)
<b>Хөлөнбуйр бүс</b>	<b>2,242,875</b>	<b>5.90</b>	<b>9.21</b>	<b>-3.31</b>	<b>25.90</b>
Хайлаар дүүрэг	365,012	6.28	6.61	-0.33	24.72
Жалайнуур дүүрэг	84,424	4.55	10.19	-5.64	22.33
Арын хошуу	257,815	7.80	8.34	-0.54	33.02
Морин даваа хошуу	228,822	6.60	9.13	-2.53	28.05
Орчон хошуу	174,023	5.56	12.08	-6.52	26.37
Эвэнх хошуу	141,102	6.24	8.32	-2.08	27.35
Хуучин Барга хошуу	50,556	5.31	9.65	-4.34	25.02
Шинэ зүүн Барга хошуу	37,007	6.66	9.40	-2.74	27.92
Шинэ баруун Барга хошуу	38,358	8.10	6.54	1.56	34.58
Манжуур хот	150,508	5.91	5.76	0.15	23.28
Ягши хот	256,396	3.65	11.00	-7.35	18.22
Жалан-Айл хот	318,933	6.31	10.85	-4.54	28.34
Эргүнэ хот	68,482	4.87	7.58	-2.71	22.23
Гэгээнгол хот	71,437	2.74	15.61	-12.87	14.63

Эх сурвалж: БНХАУ-ын үндэсний хүн амын долоо дугаар тооллогын мэдээлэлд үндэслэсэн судлаачийн тооцоолол.

Тэмдэглэл: Морин даваа хошуу гэдэг нь Морин даваа Дагуур үндэстний өөртөө засах хошуу.

Хүснэгт 3-аас Хөлөнбуйрын орон нутгуудад нялхсын эндэгдлийн түвшин ихээхэн ялгаатай байгаа нь харагдаж байна. Зарим орон нутагт 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл тэг түвшинд байхад, Ягши хот, Жалайнуур дүүрэг зэрэг орон нутагт харьцангуй өндөр байгаа нь эдгээр орон нутагт хүүхдийн эрүүл мэндийн салбарт анхаарал хандуулах шаардлагатайг харуулж байна. Бүсийн дунджаар хүн амын дундаж наслалт нь БНХАУ-ын дундаж үзүүлэлт (2020 онд 77.93 жил)-тэй харьцуулахад ойролцоо байгаа ч бүсүүдийн хооронд нэлээд ялгаатай, тодруулбал хамгийн өндөр, бага наслалттай бүсүүдийн хооронд 6.4 жилийн зөрүү байна.

## Хүснэгт 3. Хөлөнбуйр бүс, түүний засаг захиргааны нэгжүүдийн хүн амын амьдралын чанарын үзүүлэлтүүд

Засаг, захиргааны нэгж	Хүн амын амьдралын чанарын үзүүлэлтүүд						
	Нялхсын эндэгдлийн түвшин (%)	Төрөх үеийн дундаж наслалт (жил)	Насанд хүрэгчдийн бичиг үсэг үл мэдэх түвшин (%)	Хүн амын сургуульд суралцсан дундаж хугацаа (жил)	25+ насны хүн амд дээд боловсролтой хүн амын эзлэх хувь (%)	Хүүхдийн ачаалал (хүн)	Ахмадын ачаалал (хүн)
<b>Хөлөнбуйр бүс</b>	<b>4.00</b>	<b>77.2</b>	<b>1.89</b>	<b>10.03</b>	<b>15.71</b>	<b>15.65</b>	<b>18.39</b>
Хайлаар дүүрэг	1.74	81.0	1.00	11.35	26.22	13.72	17.13
Жалайнуур дүүрэг	10.39	78.2	0.95	10.14	16.17	11.06	22.21
Арын хошуу	3.97	76.4	2.08	9.08	8.37	21.70	17.11
Морин даваа хошуу	1.32	74.6	2.86	8.95	8.57	21.19	16.12
Орчон хошуу	3.09	74.9	3.06	9.47	11.98	15.91	20.88
Эвэнх хошуу	6.81	77.4	1.72	10.96	23.92	15.31	17.01
Хуучин Барга хошуу	0.00	75.7	2.28	9.82	14.59	12.47	16.02
Шинэ зүүн Барга хошуу	0.00	74.3	3.78	9.74	15.91	16.90	12.88
Шинэ баруун Барга хошуу	6.43	78.3	3.36	9.95	17.70	15.08	10.62
Манжуур хот	4.50	80.9	0.51	10.80	18.41	16.45	13.66
Ягши хот	10.63	78.3	1.23	10.19	15.55	9.70	23.59
Жалан-Айл хот	4.96	74.9	2.11	9.33	10.70	18.04	19.84
Эргүнэ хот	0.00	81.0	2.92	10.15	18.22	12.66	19.37
Гэгээнгол хот	0.00	74.8	2.67	10.22	18.22	7.47	21.95

Эх сурвалж: БНХАУ-ын үндэсний хүн амын долоо дугаар тооллогын мэдээлэлд үндэслэсэн судлаачийн тооцоолол.

Насанд хүрэгчдийн бичиг үсэг үл мэдэх байдал орон нутгуудын хувьд харьцангуй ойролцоо ба Шинэ зүүн Барга, Шинэ баруун Баргаас бусад орон нутагт ӨМӨЗО-ны дундаж үзүүлэлт (2020 онд 3.2 хувь)-ээс доогуур байна. Хүн амын сургуульд суралцсан дундаж хугацаа ч орон нутгуудын хувьд ерөнхийдөө ялгаа багатай байгаа ба улсын дундаж түвшин (2020 онд 9.91 жил)-тэй ойролцоо байна. Харин хүн амын дээд боловсрол эзэмшсэн байдал Хөлөнбуйрын орон нутгуудаар ихээхэн ялгаатай харагдаж байна. Тодруулбал, энэ үзүүлэлт хамгийн өндөр, хамгийн бага байгаа орон нутгуудыг харьцуулбал, дээд боловсролтой хүн амын хувь нь 17.82 нэгж хувиар зөрүүтэй байгаа нь боловсрол, ур чадварын тархалт Хөлөнбуйрын орон нутгуудаар жигд бус байгааг илтгэнэ.

Хөдөлмөрийн насны 100 хүн тутам өөрөөсөө гадна хэчнээн хүүхэд тэжээж буйг илтгэх хүүхдийн ачааллын үзүүлэлтийг харвал, орон нутгуудаар ялгаа байгаа ч ерөнхийдөө бүгд улсын дундаж (2020 онд 25.52)-аас доогуур байна. Мөн хөдөлмөрийн насны 100 хүн амд ногдох ахмадуудын ачаалал орон нутгуудаар тодорхой ялгаатай байгаа ч улсын дундаж (2020 онд 19.7)-тай ойролцоо байна.

Хөлөнбуйр бүсийн хүн амын бүтцийн сонгосон үзүүлэлтүүдийг Хүснэгт 4-өөс харж болно. Бүсийн хувьд нийт хүн амын хүйсийн бүтэц орон нутгуудаар нэлээд ялгаатай байна. Ихэнх орон нутагт эрэгтэй хүн ам эмэгтэйгээсээ тооны хувьд давамгайлсан байгаа ба энэ зөрүү Шинэ баруун Барга хошуунд хамгийн өндөр (100 эмэгтэй хүн тутмын ард 117.6 эрэгтэй хүн) байгаа нь засгийн газрын анхаарвал зохих асуудал хэмээн харагдаж байна. Шинээр төрж буй хүүхдүүдийн хувьд ч хүйсийн харьцаа мөн л эрэгтэй давамгайлсан байгаа ба Хуучин Барга хошуунд 140.18 болсон байгаа нь тэнд илт хүйсээр ялгаварласан төрөлтийн практик байгаа, төрөөс бодлого, үйл ажиллагаа явуулах шаардлагатайг харуулж байна.

Бүсийн нийт хүн амд ахмадуудын эзлэх хувь ерөнхийдөө үндэсний дундаж (2020 онд 18.7 хувь)-аас доогуур бөгөөд орон нутгуудад нь зөрүү бага байна. Хөдөлмөрийн насны хүн амын хувь ч орон нутгуудаараа ялгаа багатай, улсын дундаж (2020 онд 61.3 хувь)-аас

харьцангуй өндөр байгаа нь хөдөлмөрийн нөөц тэнд их буйг илтгэж байна. Хүн амын голч нас орон нутгуудаараа ялгаатай төдийгүй улсын дундаж (2020 онд 38.8 жил)-аас өндөр байгаа нь тухайн бүс бүхэлдээ харьцангуй насжилттай буюу хөгшин бүтэцтэй болсныг харуулж байна.

**Хүснэгт 4. Хөлөнбуйр бүс, түүний засаг захиргааны нэгжүүдийн хүн амын бүтцийн үзүүлэлтүүд**

Засаг, захиргааны нэгж	Хүн амын бүтцийн үзүүлэлтүүд							
	Хүн амын хүйсийн харьцаа (эмэгтэй = 100)	Төрөх үеийн хүйсийн харьцаа (эм = 100)	Ахмад настнуудын хувь (%)	Хөдөлмөрийн насны хүн амын хувь (%)	Хүн амын медиан нас (жил)	Шилжин ирэлтийн түвшин (%)	Хотын хүн амын хувь (%)	Хөдөлмөрийн орлогоор амьжиргаагаа голлон залгуулдаг хүн амын хувь (%)
<b>Хөлөнбуйр бүс</b>	<b>102.07</b>	<b>107.17</b>	<b>13.72</b>	<b>66.98</b>	<b>46.03</b>	<b>20.00</b>	<b>73.87</b>	<b>47.01</b>
Хайлаар дүүрэг	96.43	102.92	13.09	68.73	44.06	32.41	97.10	47.74
Жалайнуур дүүрэг	99.20	95.43	16.67	66.49	49.92	18.17	100.00	35.93
Арын хошуу	103.80	108.82	12.32	64.57	42.12	9.35	48.32	48.55
Морин даваа хошуу	104.73	110.14	11.74	65.21	42.67	9.11	36.22	48.31
Орчон хошуу	102.60	105.72	15.26	65.71	47.76	20.23	74.08	42.77
Эвэнх хошуу	101.53	99.77	12.86	67.46	45.76	30.98	77.17	48.07
Хуучин Барга хошуу	112.16	140.18	12.47	70.80	47.18	28.22	73.64	54.36
Шинэ зүүн Барга	105.17	109.32	9.92	70.74	43.83	23.29	55.97	60.39
Шинэ баруун Барга	117.62	104.61	8.45	73.47	42.90	29.21	65.71	64.68
Манжуур хот	102.77	105.79	10.50	69.99	42.83	45.87	100.00	52.65
Ягши хот	99.90	114.84	17.70	66.61	50.44	13.97	93.50	35.01
Жалан-Айл хот	103.28	107.08	14.39	64.58	45.54	10.69	54.57	54.35
Эргүнэ хот	104.08	121.19	14.67	68.58	47.83	17.35	79.09	48.54
Гэгээнгол хот	103.42	97.00	16.96	71.05	51.13	8.69	99.62	38.18

Эх сурвалж: БНХАУ-ын үндэсний хүн амын долоо дугаар тооллогын мэдээлэлд үндэслэсэн судлаачийн тооцоолол.

Хүн амын шилжин ирэлтийн түвшнийг харвал, бүсийн дүнгээр 1000 хүн тутамд ногдох шилжин ирэгчийн тоо 20 байгаа ч орон нутгуудаараа маш их ялгаатай (хамгийн их зөрүү нь 37.18) байгаа нь Хөлөнбуйрын орон нутгууд нийгэм, эдийн засгийн хөгжлөөрөө болон хүмүүсийн сонирхол татах байдлаараа хоорондоо ялгаа ихтэйг илтгэж байна.

Хүн амын байршил, тархалтын бүтцийг харвал, орон нутгууд хоорондоо маш их ялгаатай байна. Тухайлбал, Жалайнуур, Манжуур болон Хайлаар дүүрэгт хүн ам нь бараг бүгд хотод амьдардаг байхад, Морин Даваа, Арын хошуунд хүн амын 36-48 хувь нь л хотод амьдардаг бүтэцтэй байна. Энэ нь орон нутгуудын эдийн засгийн бүтцээс нэлээд хамааралтай. Тухайлбал, Манжуур нь худалдаа, аялал жуулчлал ихтэй боомтын хот байхад, Арын хошуу нь хөдөө аж ахуй зонхилсон эдийн засгийн бүтэцтэй юм.

Хөдөлмөрийн орлогоор амьжиргаагаа голлон залгуулдаг хүн амын хувь нь Хөлөнбуйрын орон нутгуудаар нэлээд ялгаатай байна. Ялангуяа Жалайнуур, Ягши, Гэгээнхот зэрэгт хамгийн доогуур байгаа нь тэдгээр орон нутагт хөдөлмөрийн насныхны гадагш чиглэсэн шилжилт хөдөлгөөн их явагдаж, хүн амын насжилт хурцдах төлөвтэйг анхааруулж байна.

**4.2 Хөлөнбуйр бүсийн хүн амын хөгжлийн үнэлгээ**

Хүн амын хөгжлийн ерөнхий индекс, түүнийг бүрдүүлэгч гурван дэд хэмжээсний үнэлгээний утга, хөгжлийн дэд бүрэлдэхүүнүүдийн тэнцвэртэй байдлыг илтгэх кординацын түвшний тооцоолсон утгуудыг Хүснэгт 5-д үзүүлэв.

## Хүснэгт 5. Хөлөнбуйр бүсийн хүн амын хөгжлийн индексийн тооцооны үр дүн, эрэмбээр

Орон нутаг	Хүн амын тоо, өсөлтийн индекс $S_1$		Хүн амын амьдралын чанарын индекс $S_2$		Хүн амын бүтцийн индекс $S_3$		Хүн амын хөгжлийн индекс $S$		Кординацын түвшин $D$		Хөгжлийг хязгаарлаж буй гол хүчин зүйл
	Оноо	Эрэмбэ	Оноо	Эрэмбэ	Оноо	Эрэмбэ	Оноо	Эрэмбэ	Оноо	Эрэмбэ	
Хайлаар дүүрэг	0.853	1	0.853	1	0.652	3	<b>0.786</b>	<b>1</b>	0.879	2	Хүн амын бүтэц
Манжуур хот	0.554	6	0.755	2	0.816	1	<b>0.708</b>	<b>2</b>	0.842	3	Хүн амын тоо, өсөлт
Шинэ баруун Барга хошуу	0.558	5	0.529	5	0.777	2	<b>0.621</b>	<b>3</b>	0.822	4	Хүн амын тоо, өсөлт, амьдралын чанар
Эвэнх хошуу	0.533	7	0.598	4	0.557	5	<b>0.563</b>	<b>4</b>	0.952	1	Хүн амын тоо, өсөлт
Арын хошуу	0.795	2	0.290	11	0.367	8	<b>0.484</b>	<b>5</b>	0.541	12	Хүн амын амьдралын чанар
Эргүнэ хот	0.358	11	0.651	3	0.419	7	<b>0.476</b>	<b>6</b>	0.735	10	Хүн амын тоо, өсөлт
Шинэ зүүн Барга хошуу	0.390	10	0.383	10	0.648	4	<b>0.474</b>	<b>7</b>	0.740	9	Хүн амын тоо, өсөлт, Хүн амын амьдралын чанар
Хуучин Барга хошуу	0.330	12	0.484	7	0.541	6	<b>0.452</b>	<b>8</b>	0.803	6	Хүн амын тоо, өсөлт
Жалан-Айл хот	0.732	3	0.264	13	0.339	13	<b>0.445</b>	<b>9</b>	0.539	13	Хүн амын амьдралын чанар, хүн амын бүтэц
Морин даваа хошуу	0.654	4	0.238	14	0.355	11	<b>0.416</b>	<b>10</b>	0.579	11	Хүн амын амьдралын чанар
Ягши хот	0.465	9	0.471	9	0.261	14	<b>0.399</b>	<b>11</b>	0.755	8	Хүн амын бүтэц
Жалайнуур дүүрэг	0.315	13	0.486	6	0.344	12	<b>0.382</b>	<b>12</b>	0.804	5	Хүн амын тоо, өсөлт
Орчон хошуу	0.467	8	0.274	12	0.358	9	<b>0.366</b>	<b>13</b>	0.784	7	Хүн амын амьдралын чанар
Гэгээн гол хот	0.057	14	0.473	8	0.358	10	<b>0.296</b>	<b>14</b>	0.407	14	Хүн амын тоо, өсөлт

Эх сурвалж: БНХАУ-ын үндэсний хүн амын долоо дугаар тооллогын мэдээлэлд үндэслэсэн судлаачийн тооцоолол.

Хүснэгт 5-аас харвал Хөлөнбуйр бүсийн орон нутгуудын хүн амын хөгжлийн бүрэлдэхүүн хэмжээснүүд, мөн ерөнхий индекс нь хоорондоо мэдэгдэхүйц ялгаатай байгаа нь үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийн сонголт, чиглэл зөв болсныг илтгэж байна. Өөрөөр хэлбэл, хүн амын хөгжлийг үнэлэх энэ аргачлалыг цаашид өөр бүс нутгуудад ашиглахад тохиромжтой нь харагдаж байна. Орон нутгуудын хувьд гурван дэд хэмжээс тус бүрийн доогуур үзүүлэлт нь тухайн орон нутагт хүн амын ерөнхий хөгжлийг бусдаасаа илүү доош татаж, хязгаарлаж буй гол хүчин зүйлийг илтгэнэ. Энэ агуулгаар Хүснэгт 5-ын сүүлийн баганад орон нутаг бүрийн хувьд хүн амын хөгжлөө дэмжихийн тулд эн тэргүүнд анхаарах шаардлагатай багц асуудлыг тодотгон харуулсан болно. Тус мэдээллийг бүс нутгийн хүн амын хөгжлийн стратегийг боловсруулахад анхааран ашиглах нь чухал юм.

Хөлөнбуйр бүсийн орон нутгуудын хүн амын хөгжлийн түвшний ялгааг харахын тулд ерөнхий индекс  $S$ -ийн оноонд үндэслэн орон нутгуудыг дараах гурван бүлэгт ангилсан. Үүнд дараах багтана:

$0 \leq S < 0.4$  бол хүн амын хөгжлийн түвшин “доогуур” орон нутаг,

$0.4 \leq S < 0.6$  бол хүн амын хөгжлийн түвшин “дундаж” орон нутаг,

$0.6 \leq S$  бол хүн амын хөгжлийн түвшин “өндөр” орон нутаг.

Үүний зэрэгцээ, Хөлөнбуйр бүсийн орон нутгуудын хүн амын хөгжлийн төлөв байдлыг кординацын түвшинтэй нь уялдуулан “кординац өндөр” ( $0.8 \leq D$ ), “кординац бага” ( $0 \leq S < 0.8$ ) гэсэн хоёр ангилалд бүлэглэсэн.

Дээрх ангиллуудаар ангилбал, Хөлөнбуйр бүсийн орон нутгууд хүн амын хөгжлөөрөө таван ялгаатай бүсэд хуваагдаж болохоор байна (Хүснэгт 6).

**Хүснэгт 6. Хөлөнбуйр бүсийн орон нутгуудын бүсчлэл, хүн амын хөгжлийн түвшнээр**

Бүсчлэл	Тухайн бүсэд хамаарах орон нутгууд
Хүн амын хөгжил өндөр, координац өндөр	Хайлаар дүүрэг, Манжуур хот, Шинэ баруун Барга хошуу
Хүн амын хөгжил дундаж, координац өндөр	Эвэнх хошуу, Хуучин Барга хошуу
Хүн амын хөгжил дундаж, координац бага	Шинэ зүүн Барга хошуу, Эргүнэ хот, Арын хошуу, Морин даваа хошуу, Жалан-Айл хот
Хөгжил доогуур, координац өндөр	Жалайнуур дүүрэг
Хөгжил маш доогуур, координац бага	Орчон хошуу, Ягши хот, Гэгээнгол хот

Эх сурвалж: Судлаачийн ангилал

Тайлбар: Давуу тал өндөртэй, координац бага орон нутаг байсангүй.

Хүснэгт 5, Хүснэгт 6 дахь үүр дүнгүүдийг нэгтгэн дүгнэвэл, хүн амын хөгжил өндөр, мөн хөгжлийн бүрэлдэхүүнүүдийнх нь координац өндөр (хөгжлийн бүрэлдэхүүн үзүүлэлтүүд нь харьцангуй ойролцоо, жигд түвшинд байдаг) орон нутагт Хайлаар Дүүрэг, Манжуур хот, Шинэ баруун Барга хошуу орж байна. Хайлаар болон Манжуур хотын хүн амын хөгжлийг цаашид сайжруулахын тулд одоогийн нөхцөл байдлыг хадгалахын зэрэгцээ харьцангуй сул, хязгаарлагч болж буй зүйлээ сайжруулахад анхаарах ёстой. Тухайлбал, Манжуур хотын хувьд хүн амын тоо, өсөлтийг нэмэгдүүлэхэд анхаарах хэрэгцээ байна. Шинэ баруун Барга хошууны хувьд хүн амын бүтэц нь түүний гол давуу тал болж байгаа ч хүн амын тоо цөөн, хүн амын амьдралын чанар бага байгаа явдал нь гол дутагдал юм. Ялангуяа, нялхсын эндэгдэл, бичиг үсэг үл тайлагдалтыг бууруулж, хүн амын боловсролын түвшин, дээд боловсролтой иргэдийн хэмжээг нэмэгдүүлэхэд анхаарах хэрэгтэй.

Хүн амын хөгжлийн ерөнхий түвшин дундаж, хөгжлийн үзүүлэлтүүдийнх нь координац өндөр орон нутагт Эвэнх хошуу, Хуучин Барга хошуу орж байна. Эвэнх хошуунд хүн амын тоо бага, төрөлт доогуур байгаа нь гол асуудал бөгөөд хүн амыг өсгөхөд төрийн бодлого нь чиглэх ёстой. Хуучин Барга хошуу дахь нөхцөл байдал Эвэнх хошуутай төстэй ба нийт хүн амын тоо, өсөлт бага байгаа тул хүн амын тоо, төрөлтийн түвшнийг нэмэгдүүлэхэд мөн анхаарлаа хандуулах ёстой. Хүн амын амьдралын чанар, бүтцийг сайжруулахдаа хүн амын боловсрол эзэмших байдал буюу дундаж суралцах хугацаа, дээд боловсролтой иргэдийн хувийг нэмэгдүүлэх, төрөх үеийн хүн амын хүйсийн харьцааг тэнцвэржүүлэх зэрэгт анхаарах шаардлага байна.

Шинэ зүүн Барга хошуу, Эргүнэ хот, Арын хошуу, Морин даваа хошуу, Жалан-Айл хот зэрэг таван орон нутагт хүн амын хөгжлийн ерөнхий түвшин дунд зэрэг, хөгжлийн бүрэлдэхүүн үзүүлэлтүүдийнх нь түвшин жигд бус байна. Ялангуяа координац бусад бүлгээс бага байгаа нь эдгээр орон нутгийн хүн амын хөгжлийн зарим нэг бүрэлдэхүүн харьцангуй сайн ч бусад нь эрс муу гэх мэт хөгжлийн үзүүлэлтүүд хэлбэлзэл, ялгаа ихтэй байгааг илтгэнэ. Тухайлбал, Шинэ зүүн Барга хошууны хүн амын тоо, өсөлт, амьдралын чанар доогуур түвшинд байгаа ч хүн амын бүтэц нь бусад орон нутгаас илүү буюу давуу талтай байна. Морин даваа хошуу болон Арын хошуу нь газар зүйн хувьд өөр хоорондоо хиллэдэг тул хүн амын болон орон нутгийн хөгжлийн байдал маш төстэй юм. Хоёул хүн амын тоо, өсөлтөөр тэргүүлдэг боловч хүн амын амьдралын чанар, бүтцийн хувьд сул байна. Иймд эдгээр бүс нутгуудын хүн амын хөгжлийг хангах бодлогын стратеги нь дутагдалтай талаа, ялангуяа ихээхэн хоцрогдсон үзүүлэлтүүдийг сайжруулахад чиглэх ёстой. Тухайлбал, Жалан-Айл хотын хүн амын суралцах хугацаа буюу боловсрол эзэмшилтийг нэмэгдүүлэх, дээд боловсрол эзэмшсэн иргэдийн хувийг өсгөх тал

дээр анхаарах шаардлагатай. Мөн дээд боловсрол эзэмшилт, хөдөлмөрийн насны хүн амын хувийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн насны хүн амын шилжин ирэх урсгалыг нэмэгдүүлэх зэрэгт анхаарах нь зохимжтой юм.

Хүн амын хөгжлийн түвшин доогуур боловч хөгжлийн бүрэлдэхүүн үзүүлэлтүүдийнх нь түвшин жигд, хоорондоо ойролцоо түвшинд байгаа ганц орон нутаг нь Жалайнуур дүүрэг юм. Тус дүүргийн хувьд эдийн засгийн үндсэн суурь нь нүүрсний уурхай байсан бөгөөд уурхай хаагдсанаас хойш хүн амын өсөлт буурч, гадагш шилжих хөдөлгөөн нэмэгдэн, хүн амын насжилт хурдацтай өсөх болсон нь хөгжлөөрөө сүүлд жагсахад хүргэсэн байна. Иймээс тус орон нутаг бодлогын түвшинд төрөлтийг дэмжих, гадагш шилжих хөдөлгөөнийг бууруулах, шилжин ирэлтийг нэмэгдүүлэх замаар хүн амын хөгжлийн сөрөг зүйлсээ бууруулахыг эрмэлзэх ёстой.

Орчон хошуу, Ягши хот, Гэгээнгол хотын хувьд хүн амын хөгжлийн түвшин маш доогуур, хөгжлийн бүрэлдэхүүн үзүүлэлтүүд нь ч жигд бус, өөр өөр түвшинд байна. Эдгээр орон нутгийн хувьд гол төлөв ойн аж ахуй, бичил уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Аж үйлдвэрлэлийн хөгжил өөр үе шатанд орж, байгаль орчныг эрхэмлэсэн бодлого, үйл ажиллагаанууд эрчимжиж буй тул эдийн засгийн хөгжил нь удааширсан байх талтай. Түүнээс гадна Ягши хот болон Гэгээнгол хотын өвөл хахир хүйтэн, урт хугацаатай байдаг зэрэг хүчин зүйлээс болж хүн амын гадагш шилжих хөдөлгөөн өндөр, насжилт нэмэгдэж байгаа нь эцэстээ хүн амын хөгжлийн түвшнээр хоцрогдож, дэд үзүүлэлт бүрийн хувьд бага оноо авахад хүргэсэн байна. Эдгээр орон нутагт хүн амын хөгжлийн бодлогын стратеги нь нэн түрүүнд улсын төсвөөс олгодог халамжид хүн амыг хамруулах, тэтгэмжийг нэмэгдүүлэх, төрөлтийг дэмжих замаар хүн амын насны бүтцийг сайжруулах, боловсролын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хүн амын хөгжлийг тэтгэх ажлыг алхам алхмаар нэмэгдүүлэх зэрэгт анхаарах хэрэгтэй байна.

## 5. ДҮГНЭЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Энэхүү судалгаанд ӨМӨЗО-ны Хөлөнбуйр бүсийн 14 засаг, захиргааны нэгжийн хүн амын хөгжлийн түвшнийг үнэлж, хүн амын хөгжлийг хязгаарлаж буй гол хүчин зүйлсийг илрүүлсэн. Шинжилгээг олон хэмжээст индекс тооцох аргаар, БНХАУ-ын хүн амын долоо дахь удаагийн тооллогын тоо мэдээнд үндэслэн гүйцэтгэсэн. Судалгааны дүнгээс үзэхэд Хайлаар дүүрэг, Манжуур хот, Шинэ баруун Барга хошууны хүн амын хөгжлийн ерөнхий түвшин өндөр бөгөөд хөгжлийн бүрэлдэхүүн үзүүлэлтүүд нь жигд, Эвэнх хошуу, Хуучин Барга хошууны хүн амын хөгжлийн ерөнхий түвшин дундаж бөгөөд хөгжлийн үзүүлэлтүүд нь жигд, Шинэ зүүн Барга хошуу, Эргүнэ хот, Арын хошуу, Морин даваа хошуу, Жалан-Айл хотын хүн амын хөгжлийн ерөнхий түвшин дундаж боловч хөгжлийн үзүүлэлтүүд нь жигд бус, Жалайнуур дүүргийн хүн амын хөгжлийн ерөнхий түвшин доогуур бөгөөд хөгжлийн үзүүлэлтүүд нь жигд, Орчон хошуу, Ягши хот, Гэгээнгол хотын хүн амын хөгжлийн түвшин маш доогуур боловч хөгжлийн үзүүлэлтүүд нь жигд бус байна.

Судалгааны үр дүнд үндэслэн, Хөлөнбуйр бүсийн хүн амын хөгжлийн талаар төрийн бодлогод тусгуулахаар дараах саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

### 1. Хүн амын өсөлтийг хангах талаар цогц, зохицуулалттай бодлогыг боловсруулах

Хүн ам нь эдийн засгийн үйл ажиллагаа, нийгмийн хөгжлийн үндсэн суурь байдаг. Гэвч Хөлөнбуйр бүсийн нийт хүн амын ердийн цэвэр өсөлт 1000 хүн ам тутамд “-3.31” байгаа нь хүн амын тоо цөөрч буйг илтгэж байна. Ялангуяа Гэгээнгол хотын хүн амын ердийн цэвэр өсөлт хоёр оронтой сөрөг тоогоор хэмжигдэж, Ягши хот болон Орчон хошуунд ч ердийн цэвэр өсөлтөөр хүн ам буурах түвшин нь өндөр байна. Эдгээр хандлага цаашид үргэлжилбэл хүн амын тоо маш бага болох аюултай. Иймд хүн амыг өсгөхийн тулд төрөлтөд ээлтэй нийгмийг бий болгох замаар төрөлтийг дэмжих үндэсний бодлогыг хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж

байна. Тухайлбал, хүүхдийн цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, төрөлтийг урамшуулах зэрэг олон арга хэмжээг ашиглан орон нутаг дахь төрөлтийн түвшнийг нэмэгдүүлэхэд хүчин чармайлт гаргах нь зүйтэй. Үүний зэрэгцээ Хөлөнбуйр бүсийн орон нутгийн онцлогт тохирсон хүн амыг дэмжих бодлогыг тодорхойлж, хүн амын өсөлтийг орон нутгийн хөгжлийн суурь болгон засаг захиргаа, эдийн засаг, боловсрол зэрэгтэй уялдуулж төлөвлөх шаардлагатай юм.

## *2. Хүн амын амьдралын чанарыг үргэлжлүүлэн сайжруулах*

Хөлөнбуйр бүсийн хүн амын чанарыг илэрхийлэх эрүүл мэндийн үзүүлэлтүүд үндэсний дундажтай харьцуулахад ойролцоо түвшинд байгаа ч Ягши хот, Жалайнуур дүүрэг, Эвэнх хошуу зэрэгт нялхсын эндэгдэл өндөр байна. Нялхсын эндэгдлийн түвшин өндөр байгаа шалтгааныг судалж, асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэх нь хүн амын дундах нас баралтыг бууруулахад чухал. Үүний зэрэгцээ, Хөлөнбуйр бүсийн хүн амын боловсролыг сайжруулах шаардлагатай байна. Тухайлбал, Орчон хошуу, Шинэ зүүн Барга хошуу, Шинэ баруун Барга хошуу зэрэг орон нутгийн насанд хүрэгчдийн дунд бичиг үсэг үл мэдэх байдал харьцангуй өндөр байна. Арын хошуу зэрэг найман орон нутагт хүн амын сургуульд суралцсан хугацаа 10-аас доош жил байгаа нь иргэдийн суурь боловсролын түвшнийг дээшлүүлэх хэрэгтэйг харуулж байна. Үүний тулд боловсролын хамран сургах түвшнийг нэмэгдүүлж, ахлах сургуульд элсэгчдийн хувийг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Арын хошуу, Морин давааны хошууны 25-аас дээш насны иргэдийн дунд дээд боловсролтой иргэдийн эзлэх хувь 10-аас бага, бусад орон нутагт энэ үзүүлэлт 20-иос хэтрэхгүй байна. Хайлаар дүүрэг, түүний ойр байх Эвэнх хошуунд хүн амын төвлөрөл өндөр байгаа ба бусад орон нутагт дээд боловсролтой хүн амын эзлэх хувь дэндүү бага байгаа тул орон нутагт бүртгэлтэй оюутнуудыг төрөлх нутагтаа буцахыг дэмжих бодлогыг хэрэгжүүлэх нь зүйтэй. Мөн орон нутгуудын хүн амын боловсролын суурь чадавхыг бэхжүүлэх шаардлага ч байна (Сүй Сияан Жун, 2019).

## *3. Хүйсийн харьцааны тэнцвэргүй байдлыг арилгахад анхаарах*

Хөлөнбуйр бүсийн нийт хүн амын хүйсийн харьцаа хэвийн хэмжээнд байгаа ч төрөх үеийн хүйсийн харьцаа тэнцвэргүй байна. Тухайлбал, Хуучин Барга хошуунд хамгийн ихээр хүйсийн тэнцвэр алдагдаж, төрөх үеийн хүйсийн харьцаа 114 эрэгтэй тутмын ард 84 эмэгтэй төрөлт болсон байгаа ба бусад орон нутагт ч нөхцөл байдал ноцтой байгаа тул нухацтай авч үзэх хэрэгтэй. Эдгээр орон нутагт хууль бус В-хэт авианы шинжилгээ, үр хөндөлт газар авсан байж болзошгүй тул орон нутгийн гэр бүл төлөвлөлтийн хэлтэс, эмнэлэг, олон нийтийн аюулгүй байдлын хэлтэс нь тусгайлан залруулах арга хэмжээ авч, асуудлыг үр дүнтэй шийдвэрлэх, хүн амын хөгжлийн стратеги, ирээдүйн нийгмийн хөгжлийн үүднээс нухацтай хандахыг зөвлөж байна. Үүний зэрэгцээ хүйсийн тэнцвэргүй байдлын асуудалд олон талаас нь анхаарч, охидын өсөлт хөгжил, эмэгтэйчүүдийн хөгжилд тустай холбогдох бодлого боловсруулж, эмэгтэйчүүдийн байр суурийг бэхжүүлэх, хүйсийн тэгш эрхийн байдлыг хангахад анхаарах ёстой. Соёл, сурталчилгааны алба нь эмэгтэйчүүдэд анхаарал хандуулах урт хугацааны ажлыг хэрэгжүүлж, хүйсийн тэгш эрхийн үзэл баримтлалыг эрчимтэй сурталчлах ёстой. Ерөнхийдөө хүйсийн талаарх хэвшмэл ойлголттой газруудад боломжит нөөцдөө тулгуурлан тус тусад нь судалгаа явуулж, хүйсийн тэнцвэргүй байдлын үндсэн шалтгаанд нь тохирсон зорилтот арга хэмжээг боловсруулах хэрэгтэй.

## *4. Хүн амын бууралтыг нөхөх зорилгоор шилжин ирэлтийг дэмжих*

Хүн амын шилжин ирэлтийн хэмжээ нь ихэнх тохиолдолд тухайн бүс нутгийн нийт хүн ам, насны бүтэц, хүн амын нөхөн үржихүүд эерэг нөлөө үзүүлдэг. Ялангуяа орон нутгууд руу хүн ам шилжин суурьших нь орон нутгийн эдийн засаг, соёлын солилцоо, хөгжилд таатай

нөхцөл бүрдүүлдэг. Иймээс хүн амын шилжин ирэх байдлыг төлөвлөгөөтэйгөөр дэмжвэл хүн амын тоо бага байгаа Хөлөнбуйр бүс нутагт чухал ач холбогдолтой юм. Зарим орон нутаг, тухайлбал Арын хошуу, Морин даваа хошуу, Ягши хот, Жалан-Айл хот болон Гэгээн гол хотод шилжин ирж буй иргэдийн тоо хэт бага байгаа тул орон нутгийн засаг захиргааны зүгээс юуны өмнө үзэл баримтлалаа өөрчилж, шилжин ирж буй иргэдтэй тэгш харьцах, шилжин ирсэн иргэдийг бүртгэж, суурьшуулах ажлыг хөнгөвчлөх ёстой.

Аливаа нийгэмд олон талын авьяас чадвар шаардлагатай байдаг. Шилжин ирсэн иргэдийн амьдралын хэв маяг уугуул иргэдийнхээс ялгаатай байдаг ч тохиромжтой ажлын байраа олсноор баялаг бүтээгч болдог бөгөөд тэдэнд хүндэтгэлтэй хандаж, чанартай, үр ашигтай үйлчилгээг хүртээх ёстой. Хоёрдугаарт, шилжин ирэгчдийн мэдээллийн удирдлагыг хөгжүүлж, түр оршин суух удирдлагын тогтолцоо, түрээсийн орон сууцны менежментийн арга барилыг шинэчилж, боловсронгуй болгох, түр ажилчдын нөхцөл байдал, тэдэнд үзүүлж буй үйлчилгээг сайжруулах үндэс суурийг тавих хэрэгтэй. Эцэст нь шилжин суурьшсан хүн амд төрийн үйлчилгээг тэгш хүртээж, суурьшихыг дэмжих нь зүйтэй. Шилжин ирсэн иргэдэд төрийн зүгээс ажил олоход нь дэмжлэг үзүүлснээр орон нутагт хүүхэд төрүүлэн суурьших боломжтой ба тэднийг хүүхдээ сургах, орон сууц худалдан авахад нь тэгш, чанартай үйлчилгээ үзүүлбэл орон нутагт хүн амын байдал сайжирна.

#### *5. Хөдөлмөр эрхлэлтийг анхаарч, сайжруулах*

Хөдөлмөр бол эдийн засгийн хөгжил, нийгмийн баялгийн үндсэн эх үүсвэр болдгийн хувьд ажиллах хүчинд хэдий чинээ олон хүн оролцох тусам тухайн орон нутгийн эдийн засгийн хөгжилд тус дөхөм болж, нийгмийн хөгжил ч нэмэгдэнэ. Хөлөнбуйр бүсийн нийт хүн амд хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь бага биш боловч амьжиргааны гол эх үүсвэр нь цалин хөлс, түүнтэй адилтгах орлого байдаг хүн амын хувь өндөр биш байна. Зарим нутагт, тухайлбал, Ягши хот, Жалайнуур дүүргийн хувьд энэ үзүүлэлт 50 хувьд ч хүрэхгүй байгаа нь орон нутгийн эдийн засаг, хүн амын хөгжилд сөрөг нөлөөтэй. Эдгээр газарт хөдөлмөрийн оролцоо бага байгаагийн гол шалтгаан нь насжилтын түвшин өндөр, амьжиргааны гол эх үүсвэрээ тэтгэврээс бүрдүүлдэг байдал өндөр байгаатай холбоотой. Ийнхүү хөдөлмөр эрхлэн орлого олдог хүн амын нийт хүн амд эзлэх хувь хэт бага, хүн амын дунд “амралтын маяг”-ын нийгмийн сэтгэлзүй тогтож байгаа нь нийгэм, эдийн засгийг хөдөлгөх хүч дутагдах, хүн амын бууралт үргэлжлэх, хөгжил удаашрах эрсдэлийг нэмэгдүүлнэ. Энэ байдал нь магадгүй байгалийн нөхцөл, эдийн засгийн хөгжлийн олон жилийн туршид үргэлжилсэн үйл явцтай холбоотой бөгөөд богино хугацаанд огцом өөрчлөлт хийхэд бэрхшээлтэй юм. Юуны өмнө бүх шатны засаг захиргааны нэгжийн зүгээс энэ асуудалд анхаарал хандуулж, хөдөлмөрийн оролцоог сайжруулах чиглэлээр холбогдох судалгааг хийж, илүү дэлгэрэнгүй мэдээллийг боловсруулж, асуудлын цаад учир шалтгааныг тодруулах хэрэгтэй. Хоёрдугаарт, эдгээр орон нутагт хөдөлмөрийн насны хүн амын хувийг алсдаа нэмэгдүүлэхийн тулд гэрлэлтийг дэмжих, төрөлтийг нэмэгдүүлэх үр дүнтэй бодлого боловсруулах шаардлага байна. Гуравдугаарт, эдийн засгийн бүтцийг оновчтой болгож, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, нийгмийн халамж, төрийн нөөцийн хангамжийг сайжруулж, хүн амын гадагш шилжих хөдөлгөөнийг бууруулах ёстой. Эцэст нь, татах хүч бүхий нийгмийн халамжийн сонирхол татахуйц бодлого, иргэний бүртгэлийн оновчтой тогтолцоог бий болгосноор шилжин ирэх, суурьших, ажил эрхлэх сонирхолтой иргэдийн тоог нэмэгдүүлэх боломжтой.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

### Монгол хэлээр:

- Ван Жун. (2013) Хүн амын хөгжлийн тоо баримтын системийн байгуулалт. *Тоо бүртгэл ба шийдвэрлэх бодлого*. (17). 30-33.
- Гуу Шин, Дун Чин, Ли Юувай Чен, Ван Яан. (2014). Хүн ам, аж ахуй, нийгэм, орчин тойрон, Чүнжин хотын жишээн дээр. *Чүнжин Багшийн Их Сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл*. 31 (05). 65-75 159
- Жуу Сан Жиюун. (2015) Шандун мужийн хүн амын хөгжлийн цогц үнэлгээ. *Хятадын Шинжлэх Ухааны Академийн судалгааны хүрээлэн (Гуанжу дахь дэлхийн бөмбөрцгийн хэм судлах газар)*.
- Лияан Хун (2021). Хятадын хүн амын хөгжлийн онцлог, чиг хандлага: Өмнөх хүн амын тооллогын эмхэтгэлд үндэслэсэн дүн шинжилгээ. *Өмнөд хүн амын 36-р боть*. 36 (04). 47-58.
- Сүй Сияан Жун (2019). Хүн ам цөөтэй үндэстний эдийн засгийн хөгжлийн шинжилгээ: Хөлөнбуйр бүс. 29 (02). 14-69.
- Хун Чи, Чен Зун Чан. Хүн амын хөгжлийн ерөнхий үнэгээ хийх системийг байгуулах нь. *Өмнөд орны хүн ам*. 2012. 27 (03). 3-12.
- Яин Сиү Яин, Чиү Йой Чен. (2017) Өвөр Монголын Хөлөнбуйр хотын Сияан хошууны хөгжлийн үнэлгээ. *Хөлөнбуйр Дээд Сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл*. 25 (02). 81-86.
- Ян Шиюу Ан (2022). Хүн амын хөгжлийг хэмжих тооны системийн байгуулалт ба хэрэглээний судалгаа. *Чүнжиний Үйлдвэр Худалдааны Их Сургууль*.

### Гадаад хэлээр:

- 姚三军. (2015). 山东省人口发展综合评价研究. 广州: 中国科学院研究生院(广州地球化学研究所).
- 尹秀英, 邱. (2017). 内蒙古呼伦贝尔市县域协调发展评价研究. 呼伦贝尔学院学报 *Vol 25(02)*, 81-86.
- 杨小惜. (2022). 我国人口发展监测指标体系的构建与应用研究. 重庆工商大学.
- 梁宏. (2021). 中国人口发展的特征与趋势——基于历次人口普查公报的分析. 南方人口 *Vol 36(04)*, 47-58.
- 王仲. (2013). 人口发展数据指标体系的构建. 统计与决策 *Vol17*, 30-33.
- 隋宪忠. (2019). 呼伦贝尔市人口较少民族经济发展分析. 呼伦贝尔学院学报 *Vol 27(02)*, 1-4.
- 马红旗, 陈. (2012). 我国人口发展的指标体系建设及综合评价. 南方人口 *Vol 27(03)*, 3-12.
- 高鑫, 董. (2014). 人口-经济-社会-环境”的人口发展状况评价——以重庆市为例. 重庆师范大学学报(自然科学版) *Vol 31(05)*, 68-75.